



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 102

Номгон

Үндсэн хөрөнгө акталж
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам"-ын 1.3, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК-ний үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 7 нэрийн 414,475,962 төгрөгийн анхны үнэтэй, 122,484,406,75 төгрөгийн үлдэх өртөгтэй хавсралтад заагдсан хөрөнгийг акталж, данснаас хассугай.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Актлагдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.2. Энэ тогтоолын хэрэгжилтийг 2018 оны 10 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

D:/2018/Alban bichig/TH togtool-2018

0118115



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын
19-ний өдрийн 102 дугаар тогтроолын хавсралт

БАЯНХОНГОР-ЭРЧИМ ХҮЧ ЦТХХК-НИЙ
АКТЛАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

ДД	Аймаг, сумын нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглах	Ашиглалтад орсон огноо	Нэгжийн үнэ/төгрөг/	Тоо	Нийт үнэ /төгрөг/	Хур элэгдэл	Үлдэгдэл өртөг /төгрөг/	Тайлбар
1	Баянхонгор аймаг	Баянхонгор -Эрчим хүч ЦТХХК	Гэрэлтүүлэг	10	2010.06.29	20414	8808	179806512	152461063,2	27345448,8	Гэр хорооллын 1,2,3,4,5,6,7,9 багуудын гэрэлтүүлэг нийт 663 ширхэг толгой байгаа нь хуучирч муудсан улайсах ламптай гэрэлтүүлгийн толгой нь хагарсан сольж шинэчлэх шаардлагатай байна
2	Баянхонгор аймаг	Баянхонгор -Эрчим хүч ЦТХХК	Гурван бүсийн гэрэлтүүлэг	10	2011.06.10	57389600	1	57389600	40650966,93	16738633,07	Гурван бүсийн гэрэлтүүлгийн кабель илжирч муудсанаас болж кабель шугамын нойл фаз тасарч гэрэлтүүлэг бүхэлдээ шатсан. Мөн гэрэлтүүлгийн цагаан бүрхүүл 90ш хагарч ашиглах боломжгүй болсон байна.
3	Баянхонгор аймаг	Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК	Кабель утас	28	2010.06.29	40	4000	160000	46190,44	113809,56	Жаргалант паркийн гэрэлтүүлэгний кабель
4	Баянхонгор аймаг	Баянхонгор -Эрчим хүч ЦТХХК	Явган хүний болон авто замын гэрэлтүүлэг	10	2010.06.29	1483815	72	106834680	63423428	43411252	Төв зам дагуух гэрэлтүүлэг
5	Баянхонгор аймаг	Баянхонгор -Эрчим хүч ЦТХХК	Шит шакаф	10	2005.01.01	500000	1	500000	500000	0	Хуучин шит үлдэх өртөг байхгүй тул акглах саналтай байна.
6	Баянхонгор аймаг	Баянхонгор -Эрчим хүч ЦТХХК	Кабель	28	2005.01.01	150000	1	150000	92321,58	57678,42	Төв замын тэжээлийн кабель нь нийт 46 гэрэлтүүлгийн хооронд АС дамжуулагч байна. Мөн тэжээлийн кабель нь гүйцэтгэлийн зураг байхгүй, дундаа залгаатай кабель ашиглаж байгаа тул сольж шинэчлэх шаардлагатай байна.

7	Баянхонгор аймаг	Баянхонгор -Эрчим хүч ЦТХХК	Гэрлэн чимэглэл	5	2014.11.17	69635170	1	69635170	34817585,1	34817584,9	Гэрэлтүүлгийн шон дээр байрлах цэнхэр гэрлэн чимэглэл нийт 96ш байгаа ба одоо ашиглалтын шаардлага хангахгүй унаж гэмтсэн тасарсан байгаа тул өөр шинэ ЛЕД гэрэлтүүлгээр солих шаардлагатай байна.
			Нийт дүн					414475962	291991555,3	122484406,75	

_____ оОо